

9

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН
БА ЯДУУРЛЫН СТАТИСТИК

Ю.Туул

Аль ч хөгжингүй нийгмийн эцсийн зорилго бол хүн амаа урт удаан наслуулж, тэдний эрүүл энх, тавтай, хангалуун амьдрах нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Энэ зорилгонд хүрэх бодлогыг боловсруулах, түүнийг нийгэм хэрхэн хэрэгжүүлж байгааг судлах, дүгнэж хэлэлцэхийн тулд хүн амын амьжиргааны түвшний өөрчлөлт, хандлагат анализ хийх явдал чухал.

Хүн амын амьжиргааны доод түвшинг илэрхийлэх үзүүлэлтүүдийн статистик шинж тэмдгийн ач холбогдлоос хамаарч амьжиргааны түвшин, түүний ангиллын асуудал нь өнөөг хүртэл эрдэмтдийн дунд маргалдааны халуун цэг хэвээр байгаа учир эдийн засгийн сурах бичиг, эрдэмтэд, судлаачдын бүтээлүүдэд тогтсон нэгдсэн тодорхойлолт одоогоор байхгүй байна.

Гэхдээ хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох талаар дэлхий нийтэд хамгийн өргөн тархсан арга бол хэрэглээний ухаалаг, зохистой хэмжээнд хүн амын тодорхой хэсэгт нэн шаардлагатай материаллаг болон үйлчилгээний хэрэглээг тодорхой хэмжээгээр тооцох асуудал юм. Энд:

Материаллаг хэрэглээнд: хүнсний бүтээгдэхүүн, хувцас, гутал, сууц, ахуйн болон соёлын зүйлсийн хэрэглээг хамруулна.

Үйлчилгээ: ахуйн болон соёл, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, холбоо, орон сууцны г,м хүн амын өдөр тутмын шаардлагатай үйлчилгээг хамруулна.

Өрхийн гишүүдийн тодорхой хугацаанд хэрэглэсэн материаллаг зүйлс, хүртсэн үйлчилгээний мөнгөн дүнгийн илэрхийлэлийг **амьдралын өртөг** гэнэ. Өөрөөр хэлбэл, "хүн амын амьжиргааны түвшин" нь амьдралын нөхцөл, ажил эрхлэлт, ахуй, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн байгаа байгаль орчин г,м олон асуудлыг өөртөө агуулж байна.

Хүн амын амьжиргааг 4 түвшинд ангилан үзэж болно.

1. **Хангалттай** (хүнийг бүх талаар нь хөгжүүлэхийн тулд баялагаас хүртэх хэмжээ)
2. **Боломжийн** (шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүний бие, оюун ухааныг хөгжүүлэхэд шаардлагатай ухаалаг хэрэглээний хэмжээ)
3. **Ядуу** (зөвхөн хөдөлмөрийн чадварыг хангах хэрэглээний хэмжээ)
4. **Нэн ядуу** (хүний амьдрах чадварыг хадгалах хэмжээнд буюу эрүүл мэндийн хувьд хамгийн доод түвшинд байх хэрэглээ)

Орчин үед хүн амын амьжиргааны түвшин нь нэг талаас нийгмийн хөгжлийн нөгөө талаар ард түмний аж байдлын дэвшлийн шалгуур болж байна. Иймээс "Хүн" төвтэй нийгэм, зах зээлийн эдийн засгийн үед "хүн амын амьжиргааны түвшин"-гтн үзүүлэлт нь хамгийн гол ач холбогдолтой шалгуур үзүүлэлт болж байна.

Хүн амын амьжиргааны түвшин нь өөртөө хүн амын орлого, тэдний нийгмийн хангамж, хэрэглээ, материаллаг хэрэгцээ, үйлчилгээ, амьдрах нөхцөл, чөлөөт цаг гэх мэт өргөн утгыг агуулдаг.

Хүн амын амьжиргааны түвшинг судлах үндсэн 3 аспект байж болох юм.

1. Нийт хүн амын
2. Нийгмийн тодорхой бүлгийн
3. Янз бүрийн хэмжээний орлого бүхий өрхүүдийн

Статистикийн үзүүлэлтийн системийн тусламжтайгаар л хүн амын амьжиргааны түвшнийг цогцолбороор авч судлана. Сүүлийн жилүүдэд эрдэмтэд хүн амын амьжиргааны түвшний талаар бүтцийн хувьд ялгаатай үзүүлэлтийн хэд хэдэн системүүдийг санал болгож байна.

Энэ дундаас орчин үеийн шаардлагыг тодорхой хэмжээнд хангах үзүүлэлтийн системийг улс орон бүр өөрийн онцлогийг тусган бүрдүүлж хэрэглэж байна. Гэхдээ олон улсын статистикийн аргачлал зааврын хүрээнд энэхүү үзүүлэлтийн ерөнхий систем нь аль ч улсын хувьд нэгдсэн аргачлал, тодорхойлолттой байна.

Манай улс дараахи үзүүлэлтийн системийг хэрэглэж байна. Үүнд:

1. Мөнгөн орлого (нэг хүнд /өрхөд ногдох сарын орлого)
2. Нийт орлого (нэг хүнд /өрхөд ногдох сарын орлого)
3. Мөнгөн зардал (нэг хүнд /өрхөд ногдох сарын орлого)
4. Нийт зардал (нэг хүнд /өрхөд ногдох сарын орлого)
5. Сарын дундаж нэрлэсэн цалин, хөлс
6. Тэтгэврийн сарын дундаж хэмжээ
7. Амьжиргааны доод түвшин (нэг хүнд ногдох сарын дундаж)
8. Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувийн жин, %

9. Жишсэн нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний дундаж хэрэглээ
10. Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэг,

11. Хамгийн бага орлоготой хүн амын 10 хувь болон хамгийн өндөр орлоготой хүн амын 10 хувийн хоорондын харьцаа

Жишээлбэл: Оросын Холбооны улс 1992 онд үзүүлэлтийн системээ боловсруулж Улсын Думаар хэлэлцүүлсэн байна. Орос улсын хүн амын амьжиргааны түвшний нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн систем нь 39 үзүүлэлтийг багтаасан 7 бүлгээс бүрддэг. Үүнд:

1. Мөнгөн орлого (нэг хүнд ногдох сарын орлого)
2. Бодит мөнгөн орлогын хэмжээ (өмнөх оноос)
3. Сарын дундаж нэрлэсэн цалин, хөлс
4. Тэтгэврийн сарын дундаж хэмжээ
5. Амьжиргааны доод түвшин (нэг хүнд ногдох сарын дундаж)
6. Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувийн жин, %
7. Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүн амын (бүлгийн):
 - a. нэг хүнд ногдох мөнгөн орлогын хэмжээ
 - b. сарын дундаж цалин, шагнал
 - c. сарын дундаж тэтгэвэр
8. Фондын коэффициент, (хамгийн өндөр мөнгөн орлого бүхий хүн амын 10 хувь, болон хамгийн бага мөнгөн орлоготой хүн амын 10 хувийн хоорондын харьцаа, удаа).

Үзүүлэлтийн энэ систем нь нийгмийн харьцааны өөрчлөлтөөс хамаарч өөрчлөгдөнө.

Хүн амын амьжиргааны түвшний үндсэн үзүүлэлтүүд нь нийгмийн хөгжлийн ялангуяа тодорхой бүлгийн чухал шинжүүдийг илэрхийлэхийн зэрэгцээ түүний сонгодог шалгуур болж улмаар нийгмийн статистикийн чухал бодлогуудын нэг болно. Хүн амын амьжиргааны түвшний үндсэн үзүүлэлтийн нэгдсэн системийг одоогоор бүрэн бүрдүүлээгүй, энэ ажлыг цаашид үргэлжлүүлэн хийгдэж байна гэж НҮБ-ын шинжээч, зөвлөхүүд үзэж байна. Харин энэ чиглэлээр өнөөгийн түвшинд хүрсэн нэг амжилт бол НҮБХХ-ийн мэргэжилтэнүүдийн боловсруулсан Хүний Хөгжлийн Чадавхийн Индекс (ХХЧИ) буюу хүний хөгжлийн индекс (ХХИ) юм.

ХХИ бол амьжиргааны чухал хүрээг илэрхийлсэн 3 үзүүлэлтээс бүрдсэн бүтцийн индекс болно. Энд:

1. дундаж наслалтын хүлээгдэж байгаа түвшин
2. боловсролын хүрсэн түвшин
3. нэг хүнд ногдох ДНБ

ХХИ нь дээр нэрлэсэн 3 үзүүлэлтийн индексийн арифметик дунджаар тодорхойлогддог.

Энэхүү үзүүлэлт бүрийн индексийг дараахь томъёогоор тооцно.

$$I = \frac{X_{\text{факт}} - X_{\text{мин}}}{X_{\text{мах}} - X_{\text{мин}}} \quad (1.1)$$

Энд $X_{\text{мин}}$, $X_{\text{мах}}$ — бодит хамгийн бага болон их утгууд,

$X_{\text{факт}}$ — I үзүүлэлтийн холбогдох утга. (ж: Монгол улс: 2002 онд 63,5 нас)

Дундаж наслалтын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн индекс (I_1): хамгийн бага утгыг 25 жил буюу нас, хамгийн их утга нь 85 насаар авья.

$$I_1 = \frac{X_1 - 25}{85 - 25} \quad (1.2)$$

Боловсролын түвшингийн индекс (I_2): энэ үзүүлэлтийг насанд хүрсэн хүн амын (15 ба түүнээс дээш насны) дунд бичиг үсэг тайлагдсан хүн амын эзлэх хувийн жин (i_1) - ийн 2/3 хувь мөн анхан, дунд шатны болон дээд сургуульд суралцагчдын эзлэх хувийн жингийн 1/3-ийн нийлбэрээр тодорхойлно.

$$I_2 = i_1 * 2/3 + i_2 * 1/3 \quad (1.3)$$

Бичиг үсэг тайлагдалтын индексийг i_1 ба i_2 тооцоход (ж: Монгол улс: 2002 онд $i_1 = 0,978$, $i_2 = 0,822$). $X_{\text{мин}} = 0$, $X_{\text{мах}} = 100\%$ байхаар авав.

Нэг хүнд ногдох бодит ДНБ-ний индекс (I_3):

$$I_3 = \frac{X_{\text{мах}} - X_{\text{мин}}}{X_{\text{мах}} - X_{\text{мин}}} \quad (1.4) \quad (\text{ж: Монгол улс: 2002 онд } I_3 = 0,510)$$

$$\text{ХХИ} = \frac{I_1 + I_2 + I_3}{3} \quad (1.5) \quad (\text{ж: Монгол улс: 2002 онд } I_4 = 0,679)$$

ХХИ-ийн утга 1-д ойртох тусам нийгмийн өмнө тавигдсан (дээр яригдсан) зорилгод ойртож байгаа буюу тухайн улсын хүний хөгжлийн чадавхийн түвшин хүссэн түвшинд ойртож байгааг илэрхийлнэ. НҮБХХ мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар ийм зорилгод хүрэхэд хүн амын дундаж

наслалтыг 85-д хүргэж, зохих боловсролыг нийт хүн ам эзэмшсэн мөн хүн амыг орлогын боломжтой түвшингээр хангагдсан байх ёстой юм.

Үнэн хэрэгтэй энэ үзүүлэлтийг хүний хөгжлийн чадавхийн хэмжүүрийн нийтлэг нэгж гэж үзэж болохгүй, харин энэ үзүүлэлтийн агуулганд хийгдсэн анализаар тийм түвшинд хүрэхэд улс орны өмнө өөр хичнээн зүйл хийх шаардлагатай байгааг тодорхой харуулна.

НҮБХХ-ийн 1998 оны тайланд хийсэн дүн шинжилгээгээр (дээрхи үзүүлэлтэнд) 1960-1995 онуудад дэлхийн хэмжээнд энэ индекс 247 пунктээр өссөн нь хүний хөгжлийн хандлагын талаар сүүлийн 35 жилд хүн төрөлхтөн өөрийнхөө хөгжилд гарцаагүй дэвшилд хүрсэнийг баталгаажуулсан байна. Энэ 35 жилийн туршид ХХИ-ийн зөвшөөрөгдсөн хэмжээнд (ранг) хөгжингүй орнуудаас эхний 10 байранд Канад улс (0.960), Франц (0.946), Норвег (0.943), АНУ (0.943), Исланд, Нидерланд, Швец, Финлянд, Япон, Шинэ Зеланд улс орж байна.

Харин Монгол улс нь хүний хөгжлийн чадавхаар бага буурай орны бүлэгт хамрагддаг ба Монгол улс 117 дугаар байранд байна. (Орос улс ХХИ 1995 онд 0.769 болж, 72-р байрт байсан бол 1998 онд 0.706 болж буурсан.)

Энэ үзүүлэлтийн утганд тухайн улс орны хүн ам, газар нутгийн хэмжээ чухал нөлөө үзүүлж болох юм. Ж: Том гүрэн өргөн нутагтай, хүн амын орлогын хэмжээ тэр бүс хоорондын ялгаа, амьжиргааны доод түвшний хоорондын ялгаа г,м олон нөлөөлөл байж болно. Мөн Монгол улсын хувьд ч газар, нутгийн хэмжээ, хүн амын тархай суурьшил, эрхэлж байгаа аж ахуйн төрөл г,м олон зүйлс нөлөөлж болно.

Хүн амын амьжиргааны түвшиний бас нэг гол үзүүлэлт бол хүн амын амьжиргааны доод түвшин буюу ядуурлын шугам юм. Энэ үзүүлэлт нь ядуучуудыг ядуу бус хүмүүсээс ялгахад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн доод түвшний мөнгөн орлогын хэмжээ болно. Энэ шугамыг тодорхойлох хэд хэдэн арга байдаг ба тухайн улс орны хөгжлийн түвшингээс хамаарч аль аргыг хэрэглэхийг сонгоно. Ядуурлын шугамыг үндэслэн өрхийн орлогыг тодорхой хэмжээгээр өсгөснөөр ядуу хүнийг ядуу бус хүмүүсийн дунд оруулж байгаа юм шиг хиймэл хоосон утгыг харуулж байгаа хэдий ч орчин үед ядуурлын олон шугамыг хэрэглэснээр ядуурлын олон төрлийн түвшингийн хоорондын ялгааг тодорхойлж байна. Чухамхүү ядуурлын энэхүү олон шугам нь нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын аж байдлын түвшинг харуулах үндсэн олон үзүүлэлтүүдийн харилцан хамаарал, нөлөөллийг харуулж байна.

Тэгэхээр ядуурлыг тодорхойлох, түүнийг судлах арга зүй нь тухайн улс орны хөгжлийн түвшнээс хамаарч байна. Дэлхий нийтийн туршлагаас үзэхэд буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын тухайлбал Монгол улсын одоогийн хөгжлийн түвшний хувьд "Туйлын ядуурлын" шугамыг тодорхойлох гэсэн ойлголтын дор түүнд хамаарах аргыг хэрэглэж байна.

Туйлын ядуурлын шугам нь өрхийн гишүүдийн эрүүл мэндийн зохистой харьцааг хангах хүнсний бага хэмжээний хэрэглээн дээр үндэслэнэ. Хэрэглээний сагсны нэр төрөл, түүний бүтэц, хэмжээг тусгай судалгааг үндэслэн тогтоодог.

Монгол улсын хувьд ҮСГ-аас 1960 оноос эхлэн жил бүр явуулж ирсэн "Өрхийн орлого, зарлагын судлагаа"-г үндэслэн Монгол хүний хүнсний болон хүнсний бус үндсэн хэрэглээний нэр төрөл, хэмжээг тооцон гаргасан байдаг. Ядуурлын шугам буюу хүн амын амьжиргааны доод түвшинг 1991 оноос эхлэн тодорхойлж байна. Энэ үзүүлэлт нь хэрэглээний үнийн инфляцийн түвшингээс хамаарч зарим онуудад 2-3 удаа шинэчлэн тогтоогдож байсан. Эрүүл мэндийн яам, Үйлвэрчний Зөвлөл, Улсын Төлөвлөгөөний комисс, Үндэсний статистикийн газраас хамтран байгуулсан ажлын хэсгийнхний хамтын ажлын үр дүнд 1990-ээд оны эхээр хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлалыг боловсруулж байсан түүхтэй.

Хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоож байх тухай Монгол улсын 1998 оны хуулийн заалтыг үндэслэн ҮСГ-аас жил бүр шинэчлэн тогтоож байна. Хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоож байх тухай Монгол улсын 1998 оны хуулийн заалтыг үндэслэн ҮСГ-аас жил бүр шинэчлэн тогтоож байна. Үндэсний статистикийн газраас тухайн онд боловсруулсан «Хүн амын амьжиргааны доод түвшинг улсын хэмжээнд тодорхойлох аргачлал»-ыг үндэслэн, хүн амын насны 9 бүлгээр ангилан, хүнсний хэрэглээг жишсэн дундаж хүний хэрэглээгээр тооцохдоо хүн амын эрүүл мэндийн зохистой шаардлагыг хангах нормыг харгалзан үзсэн болно. Иймээс тухайн насны бүлгийн хүн амын хүнсний хэрэглээний биет хэмжээ нь аль ч бүс нутгийн хувьд адилхан байна. Хүнсний хэрэглээний сагс нь мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, будаа, чихэр, сахар, төмс, хүнсний ногоо, бусад гэсэн хүнсний бүлэг бараанаас бүрдэнэ. Хүнсний хэрэглээ нь жишсэн хүний хоногт авбал зохих илчлэгийн хэмжээн дээр үндэслэнэ.

ҮСГ-аас 1997- 2003 онд батлан гаргасан "Хүн амын амьжиргааны доод түвшин", төгрөгөөр.

Хүн амын амьжиргааны доод түвшин. 1997-2001 он,
бензин шатахууны үнийн бүсээр,

Бүс нутаг (шатахууны үнийн)	Он	Өрнөд	Дорнод	Өмнөд	Дундад	Төв-1	Төв-2.	Төв-3.
1997-2001 он	1997	9720	9254	9340	СЭ	9031	10380	10400
	1999	14100	14500	15600	13800	16400		17600
	2000	15300	16300	15800	14700	16800		19300
	2001	18200	19900	19300	18200			23600

Хүн амын амьжиргааны доод түвшин. 2001-2003
оноор, бүс нутгийн хөгжлийн бүсээр,

Бүсчилсэн хөгжлийн бүсээр	Он	Өрнөд	Дорнод	Хангайн	Төвийн	УБ
2002-2003	2001	18200	19900	18200	19300	23600
	2002	19200	20200	19100	19700	24600
	2003	19500	20500	19900	19800	25300